

**“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын
тооллогын комиссын протокол**

2010 04 30

Шарынгол.

“Шарынгол” ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон тооллогын комисс нь:

“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд ирсэн хувь нийлүүлэгчдийн саналын хуудсыг хүлээн авч нэгтгэлээ. Үүнд.

1. Компаний хувь нийлүүлэгчдийн 2010 оны ээлжит хуралд 7 231 389 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг төлөөлөн 6908408 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 95.5 хувь нь хүрэлцэн ирсэн байна.
2. Иймд компаний тухай хууль болон дүрэмд заасны дагуу хувь нийлүүлэгчдийн хурлын ирцийг хангалттай гэж тооллогын комисс үзэж хурлын даргад мэдээлж байна.

Хурлын ажиллагаанд амжилт хүсье.

Тооллогын комисс:



Ц.Ганбат

Л.Даваасүрэн

Л.Оюундарь

**“Шарыngoл” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хуралд
хэлэлцэх асуудлын төлөвлөгөө**

2010.04.30

Шарыngoл

1. Компанийн 2009 оны үйлдвэрлэлийн болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан.
2. Компанийн ХШЗ-ийн 2009 оны ажлын тайлан дүгнэлт
3. Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалтын тухай
4. Компанийн ТУЗ, ХШЗ-ийн 2010 оны зардлын төсөв
5. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай
6. Компанийн ХШЗ-ийн гишүүдийг сонгох тухай
7. Бусад асуудал

Хурлын дарга



Б.Батмөнх

**“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын
дотоод журам**


2010.04.30

Шарынгол

1. “Шарынгол” ХК-ийн 2009 оны үйлдвэрлэлийн болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан /15 минут/
2. Компанийн ХШЗ-ийн 2009 оны ажлын тайлан дүгнэлт /10 минут/
3. Компанийн дүрмийн 4-р зүйлийн 2 дахь заалтын тухай /цаг тогтоохгүй/
4. Компанийн ТУЗ, ХШЗ-ийн 2010 оны зардлын төсөв /цаг тогтоохгүй /
5. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох /цаг тогтоохгүй/
6. Компанийн ХШЗ-ийн гишүүдийг сонгох /цаг тогтоохгүй/
7. Бусад асуудал /цаг тогтоохгүй/

Хурлыг 2 цаг тутамд 15 минутын завсарлагатай мөн өдөрт нь багтааж дуусгана.

Хурлын дарга



Б.Батмөнх

“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн

хурлын тэмдэглэл.

2010 – 04 – 30

№ 01

Шарын гол

“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2010 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 16 цагт “Глобал Шарынгол” ХХК-ийн хурлын танхимд эхэлж 18 цаг 30 минутад дуусав.

Хуралд ТУЗ-ийн дарга Б.Батмөнх, ТУЗ-ийн гишүүн Антони Милевский, Ж.Батболд, Ц.Ганбат, Жозеф Найэми, Ш.Энхбаяр, ХШЗ-ийн гишүүн Ө.Энхжаргал, ХШЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Ө.Эрдэмбилэг, ШГХК-ийн ерөнхий технологич Ж.Эрдэнэбат, ерөнхий ня-бо Л.Даваасүрэн, эдийн засагч Л.Оюундарь, нарийн бичгийн дарга Л.Батсуурь, ерөнхийлөгчийн туслах Б.Отгонзул нар байв. Орчуулагч оролцов.

Хурлыг ТУЗ-ийн хурлаар томилогдсон Б.Батмөнх удирдав. Хувь нийлүүлэгчдийн хурлын материалыг урьдчилан ТУЗ-ийн гишүүдэд болон хувьцаа байрласан үнэт цаасны брокер диллерийн компаниудаар тарааж танилцуулсан байв.

Хувь нийлүүлэгчдийн хуралд ирсэн саналын хуудсыг тооллогын комисс хүлээн авч дүнг нэгтгэж мэдээлэв. Хуралд 7 231 389 ширхэг саналын эрхтэй хувьцааг төлөөлж 6.908.408 ширхэг хувьцаа эзэмшигч буюу 95.5 хувь нь ирсэн учир хувь нийлүүлэгчдийн хурлын ирцийг хангалттай гэдгийг тооллогын комиссын дарга Ц.Ганбат мэдэгдэж хурлын ажиллагаанд амжилт хүсье гэв.

Хурлын дарга Б.Батмөнх хуралд хэлэлцэх асуудал, дотоод журмыг танилцуулж батлуулав.

1.Хэлэлцсэн нь: “Компанийн 2009 оны үйлдвэрлэлийн болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан”

Б.Батмөнх- ТУЗ-ийн тайлан нь хувь нийлүүлэгчдэд урьдчилан хүргүүлсэн учир та бүхэн танилцсан байх.Гэвч зарим хэсгийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Батсуурь товч байдлаар тодотгож танилцуулна гэв.

Л.Батсуурь – Уг тайлангийн гол гол зүйлийг товч танилцуулав.

Б.Батмөнх – Уулын ажлын байдал, түүний өрнөлтийн талаар ерөнхий технологич Ж.Эрдэнэбат танилцуулна гэв.

Ж.Эрдэнэбат – Уулын ажлын өнөөгийн байдал болон 2010 оны төлөвлөлт зэргийг эфтескоп ашиглаж товч танилцуулав. Тайлан дүгнэлттэй холбогдсон асуулт гарсангүй. /Материалыг хавсаргав/

2.Хэлэлцсэн нь: “Компанийн ХШЗ-ийн 2009 оны ажлын тайлан дүгнэлт”

ХШЗ-ийн тайлан дүгнэлтийг ХШЗ-ийн дарга Ө.Энхжаргал тайлбарлаж танилцуулав. Уг тайланг мөн тараах материалд оруулж урьдчилан хүргүүлсэн учир тодруулж асуух зүйлгүй байв. /Материалыг хавсаргав./

3.Хэлэлцсэн нь: “Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалтын тухай”

Б.Батмөнх – Энэ заалтанд компанийн зарласан хувьцааны нэрлэсэн үнэ, тоо ширхэг байдаг бөгөөд анх 7 231 389 ширхэг хувьцаа байсныг 2008 оны хурлаар бид 3 сая хувьцаа нэмж гаргахаар шийдэж дүрэмд өөрчлөлт оруулсан байгаа. Үүнийг дахин өөрчилж шийдвэр гаргах хэрэггүй гэж үзэж байна. Хувь нийлүүлэгчид ч үүнийг дэмжих байх.

Хувь нийлүүлэгчид санал нэгтэй гэдгээ хэлээд саналын хуудсаар санал өгье гэв.

4.Хэлэлцсэн нь: “Компанийн ТУЗ, ХШЗ-ийн 2010 оны зардлын төсөв”.

Б.Батмөнх – Зардлын төсөв, хурлаас гарах тогтоолын төслийг тараах материалаар урьдчилан хүргүүлсэн учир ТУЗ-ийн нарийн бичгийн дарга товч танилцуулна гэв.

Л.Батсуурь – Зардлын төсвийг хураангуйлан танилцуулав. Энэ асуудлаар санал ярьсангүй.

5.Хэлэлцсэн нь: “Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох, ХШЗ-ийн гишүүдийг сонгох тухай”

Б.Батмөнх – Компанийн ТУЗ болон ХШЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхээр ирүүлсэн материалыг нарийн бичгийн дарга Л.Батсуурь танилцуулна гэв.

Л.Батсуурь – Хурлын материал бэлтгэж саналын хуудсанд нэр бичихээс өмнө Б.Батмөнх, Ж.Батболд, Д.Байлхүү, Д.Даянбилгүүн, Ш.Энхбаяр, Антони Милевский, Жозеф Найэми, Жеймс Пассин, Ц.Ганбат нар анкет бүхий хүсэлтээ ирүүлсэн. Дараа нь Ян Спенсе анкет бүхий хүсэлт ирүүлсэн учир саналын хуудсанд бичигдээгүй юм гэв. Ингээд нэр дэвшигчдийн намтар түүхийг хүн бүрээр уншиж сонсгов.

ХШЗ-ийн гишүүнд Ө.Энхжаргал, Ө.Эрдэмбилэг, Б.Эрдэнэтуяа нар нэрээ дэвшүүлсэн гээд мөн намтар түүхийг нь уншиж сонсгов. Хувь нийлүүлэгчид саналын хуудсаар саналаа өгөх учиртай гэв. Гэтэл нэр дэвшигч Ш.Энхбаяр би ТУЗ-ийн гишүүнээр нэр дэвших саналаасаа татгалзаж нэрээ татаж байна гэв. Өөр санал гарсангүй.

6.Хэлэлцсэн нь: Бусад асуудал.

Б.Батмөнх – Энэ асуудалд эрхэм Жеймс Пассины санал гаргаснаар дотоод гадаадын сангаас зээл авч хөрөнгө оруулах асуудал юм. Үүнд нийт 4,5 сая ам.долларын асуудалд санал хураая гэв. Саналын хуудсаар санал авна гэв.

Хуралд хэлэлцэх асуудал дуусч тооллогын комисс дүнгээ гаргаж тогтоолын төсөл бэлдэх хугацаанд түр завсарлав. 15 минут завсарлаад хурал үргэлжилж тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэж тооллогын комиссын тогтоолыг тооллогын комиссын дарга Ц.Ганбат уншиж сонсгов. Үүнд:

* Компанийн ТУЗ болон ХШЗ-ийн тайлангийн тухай тогтоол № 1

Уг тогтоолд ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлангийн талаарх санал ирүүлсэн хувь нийлүүлэгчдийн 6 908 408 ширхэг хувьцааны саналын 100 хувь нь хангалттай гэж дүгнэсэн, мөн ХШЗ-ийн тайлангийн талаар дээрхи хэмжээний хувьцааны саналын 100 хувь нь хангалттай гэж дүгнэсэн тул ТУЗ болон ХШЗ-ийн 2009 оны ажлын тайлан дүгнэлтийг тус тус батлах саналыг хувь нийлүүлэгчдийн хуралд оруулах.

* Компанийн ТУЗ болон ХШЗ-ийн 2010 оны зардлын төсдийн тухай тогтоол № 2.

Уг тогтоолд 6 908 408 хувьцааны санал буюу 100 хувь нь зөвшөөрсөн санал өгсөн учир батлах саналыг хувь нийлүүлэгчдийн хуралд оруулах.

* Компанийн ТУЗ – ийн гишүүдийг сонгох санал хураалтын дүнгийн тухай тогтоол № 3.

Уг тогтоолд ТУЗ-ийн гишүүнээр сонгохоор хувь нийлүүлэгчдийн гаргасан саналын дүнг тоолж гаргавал нийт 6 908 408 ширхэг хувьцааны санал 100 хувиар

Антони Милевский

Б.Батмөнх

Ж.Батболд

Д.Байлхүү

Д.Даянбилгүүн

Жеймс Пассин

Жозеф Найэми

Ян Спенс

Ц.Ганбат нарыг дэмжсэн тул хувь нийлүүлэгчдийн хуралд батлуулахаар оруулах

* Компанийн ХШЗ –ийн гишүүдийг сонгох санал хураалтын дүнгийн тухай тогтоол № 4.

Уг тогтоолд ХШЗ-ийн гишүүнээр нэр дэвшсэн Ө.Энхжаргал, Ө.Эрдэмбилэг, Б.Эрдэнэтуяа нарыг тус бүр 100 хувь дэмжсэн учир хувь нийлүүлэгчдийн хуралд батлуулахаар оруулах.

* Бусад асуудал буюу хөрөнгө оруулах зорилгоор зээл авах тухай санал хураалтын дүнгийн тухай.

Энэ асуудлаар нийт 6 908 408 ширхэг хувьцааны санал буюу 100 хувь нь зээл авахыг зөвшөөрсөн учир хувь нийлүүлэгчдийн хуралд батлуулахаар оруулах.

* “Шарынгол” ХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалтын талаар хуралд оролцсон хувь нийлүүлэгчид 100 хувь, 2008 онд өөрчилсөн дүрмийг хэвээр нь байлгахаар

санал өгсөн тул хувь нийлүүлэгчийн хурлаас тогтоол гаргах шаардлагагүй гэж үзэж байна гэв.

Шийдвэрлэсэн нь:

“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын тооллогын комиссын тогтоолуудыг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хурлаас гарах тогтоолын төслийг нарийн бичгийн дарга Л.Батсуурь уншиж сонсгов. Үүнд:

1. “Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон тайлан тэнцлийн дүн,ногднл ашгийн тухай” тогтоол № 1
2. “Компанийн ТУЗ,ХШЗ-ийн ажлын тайлан болон Аудит-ын тайлангийн тухай” тогтоол№ 2.
3. “Компанийн ТУЗ, ХШЗ-ийн 2010 оны зардлын төсөв батлах тухай” тогтоол № 3
4. “Компанийн ТУЗ болон ХШЗ-ийн гишүүдийг сонгох тухай” тогтоол №4 эдгээр болно.

Хуралд оролцсон хувь нийлүүлэгчдийн 100 хувийн саналаар дээрхи тогтоолуудыг батлав. /Тогтоолуудыг хавсаргав./

Б.Батмөнх – Хуралд хэлэлцэх асуудлаа амжилттай,бүрэн хэлэлцлээ. Бидэнтэй хамт ажиллаж байсан Ш.Энхбаярт баярласнаа илэрхийлье. Геологи хайгуулын нөөц тогтооход 4,5 сая ам.долларын зээл авах тухай санал гаргаж үр дүнтэй шийдвэр гаргахад тусалсан Жозеф Найэмид баярлалаа гэв.

Хурлын ажиллагаа үүгээр өндөрлөв.



Танилцсан: Хурлын дарга. / Б.Батмөнх /

Тэмдэглэл хөтөлсөн:

Нарийн бичгийн дарга. / Л.Батсуурь /

**“Шарыngoл” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн
хурлын тооллогын комиссын тогтоол**

2010.04.30

№01

Шарыngoл

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон
Хянан шалгах зөвлөлийн тайлангийн
Тухай

“Шарыngoл” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хуралд хэлэлцсэн ТУЗ болон ХШЗ-ийн 2009 оны ажлын тайлан дүгнэлтийн талаар хувь нийлүүлэгчдээс гаргасан саналыг шалгаж тоолсон дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ийн тайлан дүгнэлт бүхий тайлангийн талаах санал ирүүлсэн хувь нийлүүлэгчдийн 6908408 ширхэг хувьцааны саналын 100 хувь нь хангалттай гэж дүгнэсэн.
2. ХШЗ-ийн тайлан дүгнэлтийн талаар санал ирүүлсэн хувь нийлүүлэгчдийн 6908408 ширхэг хувьцааны саналын 100 хувь нь хангалттай гэж дүгнэсэн тул ТУЗ болон ХШЗ-ийн 2009 оны ажлын тайлан дүгнэлтийг тус тус батлах саналыг хувь нийлүүлэгчдийн хуралд оруулсугай.



Тооллогын комисс:

Ц.Ганбат

Л.Даваасүрэн

Л.Оюундарь

**“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн
хурлын тооллогын комиссын тогтоол**

2010.04.30

№02

Шарынгол

Компанийн удирдлагын төсвийн
тухай

“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн ТУЗ болон ХШЗ-ийн 2010 оны зардлын төсвийн тухай хувь нийлүүлэгчдээс гаргасан саналыг тоолоход нийт 6908408 саналын эрхтэй хувьцаанаас уг төсвийг 6908408 ширхэг хувьцааны санал буюу 100 хувь нь зөвшөөрснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн 2010 оны зардлын төсвийг 1-р хавсралтаар, ХШЗ-ийн зардлыг 2-р хавсралтаар тус тус батлах саналыг хувь нийлүүлэгчдийн хуралд оруулсугай.



Тооллогын комиссын
Дарга
Гишүүд

Ц.Ганбат
Л.Оюундарь
Л.Даваасүрэн

**“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн
хурлын тооллогын комиссын тогтоол**

2010.04.30

№03

Шарынгол

Санал хураалтын дүнгийн тухай

“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлаас компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоор хувь нийлүүлэгчдээс кумлятив аргаар гаргасан саналыг тоолж дүнг гаргавал:

1. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Антони Милевский төлөө хувь нийлүүлэгчдээс нийт 6908408 ширхэг хувьцааны санал буюу 100 хувь
2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Б.Батмөнх төлөө хувь нийлүүлэгчдээс 6908408 нийт ширхэг хувьцааны санал буюу 100 хувь
3. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Ж.Батболд төлөө хувь нийлүүлэгчдээс нийт 6908408 ширхэг хувьцааны санал буюу 100 хувь
4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Д.Байлхүү төлөө хувь нийлүүлэгчдээс нийт 6908408 ширхэг хувьцааны санал буюу 100 хувь
5. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Д.Даянбилгүүн төлөө хувь нийлүүлэгчдээс нийт 6908408 ширхэг хувьцааны санал буюу 100 хувь
6. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Жеймс Пассин төлөө хувь нийлүүлэгчдээс нийт 6908408 ширхэг хувьцааны санал буюу 100 хувь
7. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Жозеф Найэми төлөө хувь нийлүүлэгчдээс нийт 6908408 ширхэг хувьцааны санал буюу 100 хувь
8. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Ян Спенс төлөө хувь нийлүүлэгчдээс нийт 6908408 ширхэг хувьцааны санал буюу 100 хувь
9. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Ц.Ганбат төлөө хувь нийлүүлэгчдээс нийт 6908408 ширхэг хувьцааны санал буюу 100 хувь

Тооллогын комиссоос **ТОГТООХ НЬ:**

Нэг: Тус компанийн хувь нийлүүлэгчдийн олонхийн санал авсан

1. Антони Милевский
2. Б.Батмөнх
3. Ж.Батболд
4. Д.Байлхүү
5. Д.Даянбилгүүн
6. Жеймс Пассин
7. Жозеф Найэми

**“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн
хурлын тооллогын комиссын тогтоол**

2010.04.30

№04

Шарынгол

Санал хураалтын дүнгийн тухай

“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлаас компанийн хянан шалгах зөвлөлийн гишүүдийг сонгохоор хувь нийлүүлэгчдээс кумлятив аргаар сонгосон саналыг тоолж дүнг гаргавал:


а. ХШЗ-ийн гишүүд нэр дэвшигч Ө.Энхжаргалын төлөө хувь нийлүүлэгчдээс нийт 6908408 ширхэг хувьцааны санал 100 хувь

б. ХШЗ-ийн гишүүд нэр дэвшигч Ө.Эрдэмбилэгийн төлөө хувь нийлүүлэгчдээс нийт 6908408 ширхэг хувьцааны санал 100 хувь

в. ХШЗ-ийн гишүүд нэр дэвшигч Б.Эрдэнэтуяагийн төлөө хувь нийлүүлэгчдээс нийт 6908408 ширхэг хувьцааны санал 100 хувь тус тус байв.

Тооллогын комиссоос тогтоох нь:

- а. Ө.Энхжаргал
- б. Ө.Эрдэмбилэг
- в. Б.Эрдэнэтуяа нарыг Хянан шалгах зөвлөлийн гишүүнээр батлуулахаар хувь нийлүүлэгчдийн хуралд оруулахаар тогтоосугай.



Тооллогын комисс

Ц.Ганбат
Л.Даваасүрэн
Л.Оюундарь

**“ ШАРЫН ГОЛ “ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ.**

2010 .04.30

Дугаар 1

Шарын гол

**Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон
тайлан тэнцлийн дүн, ногдол ашгийн тухай.**

“ Шарын гол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2009 оны 4 дүгээр сарын 30 – ний өдрийн хурлын тэмдэглэл, тооллогын комиссын дүнг үндэслэн
Тогтоох нь:

1. Тус компанийн 2009 оны жилийн үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагааны тухай төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан дүгнэлтэнд тусгагдсан компанийн 2009 оны тайлан тэнцлийн нийт хөрөнгийг 9.535.128.5 мян төгрөгөөр

- Үндсэн хөрөнгийг	11.996.161.7	мян.төгрөгөөр	
- Эргэлтийн хөрөнгийг	6.576.884.3	мян .төгрөгөөр	
- Нийт орлогыг	9.126.847.1	мян.төгрөгөөр	
- Ашиг / алдагдал /	219.919.8	мян.төгрөгөөр	тус тус тооцож

тайлан тэнцлийн дүнг баталсугай.

2. Цаашид уулын ажлын хүндрэл, техникийн парк хуучирснаас зайлшгүй хийгдэх засвар шинэчлэл, хөрөнгө оруулалтанд төлөвлөсөн зардлын хэмжээ өссөн бөгөөд ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадваргүй болох тул 2009 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.



Хурлын дарга Б.Батмөнх

**“ ШАРЫНГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 04 30

дугаар 2

Шарын гол

**Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Хянан шалгах зөвлөлийн
ажлын тайлан болон Аудитын тайлангийн тухай.**

“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн ТУЗ,ХШЗ-ийн 2009 оны ажлын тайлангийн тухай тооллогын комиссын тогтоол болон тус компанийн 2009 оны санхүүгийн тайлан тэнцэлд хараат бус аудитын байгууллагаас хийсэн санал дүгнэлтийг үндэслэн

ТОГТООХ НЬ:

- 1.Тус компанийн ТУЗ-ийн 2009 оны ажлын тайланг хангалттай гэж үзсүгэй.
- 2..Тус компанийн ХШЗ-ийн 2009 оны ажлын тайланг хангалттай гэж үзсүгэй.
- 3.Тус компанийн 2009 оны санхүүгийн тайлан тэнцэлд тусгасан орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангуудад хараат бус аудиторын байгууллагаас хийсэн тайланг баталж зөвшөөрсүгэй.



ХУРЛЫН ДАРГА.

/Б.Батмөнх/

**“ШАРЫНГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ.**

2010 04 30

дугаар 3

Шарын гол

**Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, хянан шалгах
зөвлөлийн 2010 оны зардлын төсөв батлах тухай.**

“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн 2010 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн хурлын тэмдэглэл, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **Тогтоох нь:**

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2010 оны зардлын төсвийг 1-р хавсралтаар, Хянан шалгах зөвлөлийн зардлын төсвийг 2-р хавсралтаар тус тус баталсугай.

2. Компанийн удирдлагын болон хянан шалгах зөвлөлийн зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Хянан шалгах зөвлөлд даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА /Б.Батмөнх/

**“ШАРЫНГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ
НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ.**

2010 04 30

дугаар 4

Шарын гол

Компанийн ТУЗ болон ХШЗ
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хууль, компанийн дүрмийн холбогдох заалт, хувь нийлүүлэгчдийн хурлын тооллогын комиссын санал хураалтын дүнг үндэслэн тогтоох нь:

1. “Шарынгол” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр нэр бүхий хүмүүсийг 2010 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 2 жилийн хугацаагаар сонгосугай.

Үүнд 1. Антони Милевский

2. Б.Батмөнх

3. Ж.Батболд

4. Байлхүү

5. Ц.Ганбат

6. Д.Даянбилгүүн

7. Жеймс Пассин

8. Жозеф Найэми

9. Ян Спенс

2. Компанийн ХШЗ-ийн гишүүнээр доорхи нэр бүхий хүмүүсийг 2010 оны 4 сарын 30 – ны өдрөөс 2 жилийн хугацаагаар сонгосугай.

Үүнд: 1. Ө.Энхжаргал

2. Ө.Эрдэмбилэг

3. Б.Эрдэнэтуяа



Хурлын дарга

Б.Батмөнх

**“Шарынгол” ХК-ийн хувь
нийлүүлэгчдийн хурлын
ТОГТООЛ**

2010.04.30

дугаар 5

Шарынгол

Зээлийн тухай

“Шарынгол” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн Тогтоох нь :

1. “Шарынгол” ХК-ийн уулын ажлын цаашдын үйл ажиллагаатай уялдуулан Firebird Mongolian fund ltd, Firebird Global master fund ltd, Firebird Global master fund 2 ltd зэрэг компаниудын сангаас богино хугацаатай зээл авахыг зөвшөөрсүгэй.
2. Авсан зээлийн зарцуулалтанд байнгын хяналт тавьж зарцуулалтын талаарх мэдээллийг ТУЗ-ийн хуралд тайлагнаж байхыг гүйцэтгэх захирал (С.Насанбат) ерөнхий ня-бо (Л.Даваасүрэн) нарт даалгасугай.



Хурлын дарга

Б.Батмөнх

**“Шарын гол” ХК-ийн 2009 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон
санхүүгийн үйл ажиллагааны талаарх төлөөлөн удирдах
зөвлөлийн гаргасан дүгнэлт тайлан**

/Б.Батмөнх-ТУЗ-ийн дарга/

Нэг. 2009 оны уулын ажлын зорилт түүний биелэлтийн тухай

Шарын голын нүүрсний уурхай нь 2009 онд уулын ажлын батлагдсан төлөвлөгөөгөөр жилдээ 2000,0 м.м³ хөрс хуулж , 450,0 м.тн нүүрс олборлон борлуулж , 50,0 м.тн нүүрсний шилжих нөөцтэй байж , цаашилбал 2010-2011 оны нөөц нээх бэлтгэл уулын ажлын өрнөлтийг хангах зорилготой ажилласан.
2009 оны уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг урьд онтой харьцуулан үзүүлбэл :

ҮЗҮҮЛЭЛТ	Х/Н	2008 оны гүйц.	2009 оны төл.	2009 оны гүйц.	Зөрүү	
					2009г-2008г	2009г-2009т
Нүүрс гаргалт	м.тн	548.3	450.0	420.6	-127.7	-29.4
Нүүрс борлуулалт	м.тн	545.6	450.0	425.8	-119.8	-24.2
Нийт хөрс	м.м ³	2384.9	2000.0	1534.1	-850.8	-465.9
Тээвэргүй	м.м ³	1325.3	1060.0	570.0	-755.3	-490.0
Автын хөрс	м.м ³	1059.6	940.0	964.1	-95.5	24.1
Нийт цул	м.м ³	2806.7	2346.2	1857.6	-949.1	-488.6
Өрөмдлөг	м.у.м	45.4	97.0	44.5	-0.9	-52.5

2009 оны уулын ажлын өрнөлт батлагдсан төлөвлөгөөний үндсэн чиглэлийн дагуу явагдсан.

1. Авто тээвэртэй хөрс хуулалт

Авто тээврээр 940,0 м.м³ хөрс хуулахаар төлөвлөснөөс 964,1 м.м³ хөрс хуулж 102,6% биелэлттэй ажилласан байна. 2009 оны эхний хагаст автомашины гаралтын тоо илүү байсан учир авто тээвэртэй хөрс хуулалтын ажлын төлөвлөгөө биелэж байсан ба сүүлийн хагаст машин хүрэлцэхгүй шалтгаанаас төлөвлөгөө тасалдсан боловч эхний хагас жилийн илүү тээвэрлэлтээр жилийн төлөвлөгөө биелсэн харагдаж байна.
Авто тээвэртэй хөрс хуулалт Хойд блокийн нүүрсний нөөц нээх төвшинд хийгдсэн б олно.

2. Тээвэргүй хөрс хуулалт

Тээвэргүй хуулалтаар 1060,0 м.м³ хөрс хуулахаар төлөвлөснөөс 570,0 м.м³ хөрс хуулж 53,8% биелэлттэй байна. 2009 оны эхний хагас жилд тээвэргүй хуулах хөрсний 67,9%-ийг хуулах байсан боловч алхагч экскаваторын сэлбэг, өрмийн машинуудын эвдрэл саатлаас шалтгаалан гүйцэтгэл 22,1%-тай байв. Оны сүүлийн хагаст автомашины хүрэлцээгүй байдлыг харгалзан хойд блокийн нүүрсний давхаргын дээрхи хөрс хуулалтыг идэвхжүүлэх зорилгоор ЭКГ-4У экскаваторуудыг тээвэргүй хуулалтанд ажиллуулж сүүлийн хагас жилийн тээвэргүй хөрс хуулалтын төлөвлөгөө 120,9%-ийн биелэлттэй гарсан боловч оны эхэнд төлөвлөгөө тасарснаас жилийн гүйцэтгэл 53,8%-ийн биелэлттэй байна.
Дээрх арга хэмжээ нь тээвэргүй хөрс хуулалтыг эрчимжүүлэх үр ашигтай байсан хэдий ч 2010 онд нүүрсний давхаргыг нээх давтан шидэлтийн ажлын хэмжээг нэмэгдүүлсэнээр цаашид хүндрэл үзүүлж байгаа юм.

3. Нүүрс олборлолт

2009 онд олборлосон нүүрсний 53,2%-ийг үндсэн мөрөгцөгөөс , 46,8%-ийг улнаас , далд ашиглалтаар 3,1%-ийг олборлосон бөгөөд уулын ажлын зүсэлтийн шугам 10-13 хооронд улнаас нийт 196,8 мян.тн нүүрс олборлосон.
Дархан , Эрдэнэтийн станцууд авсан нүүрснийхээ үнийг төлөхгүй байснаас 6-9 саруудад нүүрс нийлүүлэлтийг багасгасан , хойд блокийн хөрс хуулалт хоцорч явагдаж байснаас нээгдэх онд шилжих нөөц тасалдах магадлалтай байсан зэрэг шалтгаанаас нүүрс олборлолтын төлөвлөгөө тасалдсан байна.
2010.01.01-нд 100,0 м.тн нүүрсний нээгдсэн нөөцтэй шилжсэн.

4. Өрөмдлөг тэсэлгээ

2009 онд нийт 97,0 м.у.м өрөмдлөг хийхээс 44,6 м.у.м өрөмдлөг хийгдэж өрмийн машинуудын эвдрэл саатал их байснаас өрөмдлөгийн ажлын жилийн төлөвлөгөө тасалдсан

экскаваторын шанаганы ээмэг хийх арга, ЭКГ 8И экскаваторын компрессор турших төхөөрөмж гэх мэт ашигтай загвар үйлдвэрлэлд нэвтрүүлж 15.0 сая төгрөгийн ашиг гаргалаа.

Ачигч HL 780-ын моторыг хуучин Терекс 3305-ын мотор тааруулж тавих, экскаватор LC 450-ын моторыг өөр мотороор орлуулан тавих зэрэг оновчтой өөрийн боломжоо ашигласан санал санаачлагуудыг хэрэгжүүлж удаан зогссон тоног төхөөрөмжүүдээ ажилд орууллаа.

Цахилгаан хөдөлгүүрүүдийн ороох утас олдоц муутай ховор байгааг харгалзан хөдөлгүүрийн ороомогийн утасны шатаагүй хэсгийг эргүүлэн ашиглах замаар дахин ашиглаж 6-7 сая төгрөгийн хэмнэлт гаргасан.


ЭШ 10/70-ын хуучин шанаганы эрүү залгах, нөхөлт хийх зэргээр сэргээн засварлаж эргүүлэн ашиглаж ажиллаа.

Техник, тоног төхөөрөмжүүдэд зарцуулсан зардал

Тоног төхөөрөмжийн төрөл	марк	Паркийн тоо ширхэг	2009 онд засвар хийгдсэн	2009 онд зарцуулсан зардал м.төгрөг	Одоо ашиглаж байгаа хэд
Экскаватор	ЭШ алхагч	3	3	459,767.2	3
	ЭКГ гинжит	7	6	466,971.1	6
Автосамосвал	Терекс	2	2	302,998.1	2
	САТ	3	3	763,928.5	3
өрмийн машин	СБШ	5	4	258,254.6	4
Бульдозер	Коматцу	1	1	262,715.6	1
Дугуйт болон гинжит экскаватор	САТ	1	1	52,322.3	1
	Хьюнда экс-ууд	2	2	241,744.5	2
Бусад машин механизм тоног төхөөрөмж туслах нэгжүүд		33	32	734,537.1	30
ДҮН		57	54	3,543,239.0	52

Хоёр 2009 оны санхүүгийн үйл ажиллагааны талаар:

1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт:



2. Борлуулалтын орлогын талаар:


А. Нүүрсний үнэ

2009 онд нэг тонн нүүрсийг 22426.7 төгрөгөөр борлуулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 20263.1 төг-өөр борлуулсан байна.

- 1 тн нүүрсний үнэ буурсан шалтгаан нь нүүрсний чанар жилийн турш муу байснаас илчлэгийн зөрүүнээс болж ДА ДЦС-д нийлүүлсэн нүүрснээс 310.9 сая.төг, Эр ДЦС-д нийлүүлсэн нүүрснээс 413.0 сая.төгрөг нийт 723.9 сая төгрөг олох боломжоо алдсан байна.
- Мөн жингийн зөрүүнээс Дархан ДЦС-д нийлүүлсэн нүүрснээс 18.5 сая төгрөг, Эрдэнэт ТЭЦ-д нийлүүлсэн нүүрснээс 13.0 сая төгрөг нийт 31.5 сая төгрөг алдсан байна.

Эдийн засаг нийгмийн хөгжлийн сангаас ажиллагсадын нийгмийн асуудалд зориулж 120.2 сая төгрөг зарцуулав.

2009 оны зардлын бүтэц



4.Өр авлагын талаар

Авлага

Тус компани нь 2009 оны санхүүгийн тайлангаар 4480.3 сая төгрөгийн авлагатай гарав. Өнгөрсөн оны мөн үеэс 348.5 сая төгрөгөөр буурсан байна. Сэлбэг материал худалдан авах, борлуулах, дараа тайлан зэрэгтэй холбоотойгоор байгууллага хүмүүсээс нийт 2851.0 сая төгрөгийн авлага үүссэн нь нийт авлагын 63.6 хувийг, нүүрсний авлага 36.4 хувийг эзэлж байна.

Оны эхэнд сэлбэг материалаар 2751.9 сая төгрөгийн авлага байснаас тайлангийн хугацаанд 199.6 сая төгрөгөөр авлага буурсан байна.

Нүүрсний авлага 1629.3 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 123.0 сая төгрөгөөр буурсан байна.

Нүүрсний авлагаас 983.3 сая төгрөгний авлага буюу 60.4 % нь Эрдэнэт ДЦС, Дархан ДЦС-аас авах авлага юм.

Авлагын байдлыг төрөл тус бүрээр харуулбал:

/сая.төгрөгөөр/

д/д	Авлагын төрөл	2007 XII.31	хувь	2008 XII.31	хувь	2009 XII.31	хувь
1	Нүүрсээр авах авлага	1778.3	24.3	1752.3	36.3	1629.3	36.4
2	Сэлбэг материалаар	5186.7	70.8	2751.9	57.0	2552.3	57.0
3	Хүмүүсээс авах авлага	6.0	0.1	5.3	0.1	1.7	0.0
4	Цахилгаанаар	201.8	2.8	244.0	5.1	62.6	1.4
5	халамжийн сангаас	4.7	0.1	4.7	0.1	4.7	0.1
6	Дараа тайлангаар	146.1	2.0	67.6	1.4	54.0	1.2
7	Урьдчилж гарсан зардал			3.0	0.1	175.7	3.9
	Дүн	7323.6	100.0	4828.8	100.0	4480.3	100.0

Өглөг

2009 онд нийт 8100.2 сая төгрөгний өглөгтэй байгаагийн 32.9 хувь буюу 2667.4 сая төгрөг нь сэлбэг материалын, 31.0 хувийг Японы төслийн буцалтгүй тусламжийн зээлээр авсан Терекс машины өр, бүх төрлийн татвар, НДШ-ийн өглөгт 2.4 хувь, 33.7 хувийг бусад богино хугацаат өглөг эзэлж байна.

Тус компанийн өглөгийн байдлыг төрөл тус бүрээр ангилан харуулбал: /сая.төгрөгөөр/

$$YXXX = (284,578,670.16 + 0.00) / 5,591,931,384.04 = 0.05$$

Бүтээмжийн шинжилгээ

1. Хөдөлмөрийн бүтээмж
 $XБ = У/цул / ажилчдын тоо$
 $XБ = 1,857,600 / 493 = 3,768.0 м^3$

Ашигт ажиллагааны шинжилгээ

1. Борлуулалтын өгөөж буюу цэвэр ашгийн түвшин =
цэвэр ашиг/борлуулалтын орлого
 $ЦАТ = 219,919,808.36 / 8,812,255,031.28 = 2.5$
2. Хөрөнгийн ашигт ажиллагаа = татвар төлөхийн өмнөх ашиг / НХ
 $XАА = 246,500,353.26 / 9,535,128,524.67 = 0.026$
3. Эзэмшигчийн өмчийн өгөөж = цэвэр ашиг / эзэмшигчийн өмч
 $ЭӨӨ = 219,919,808.36 / 1,434,857,097.43 = 0.153$

Үр ашгийн харьцаа

1. Авлагын эргэцийн тоо = цэвэр борлуулалт / авлага
 $АЭТ = 8,812,255,031.28 / 4,304,257,616.26 = 2.05$
2. Авлагын эргэцийн өдөр = 365 / авлагын эргэцийн тоо
 $АЭӨ = 365 / 2.05 = 178$ өдөр
3. Бараа материалын эргэц = (бор бүт өртөг х12 сар) / БМ
 $БМЭ = (8,302,128.480.0 \times 12 сар) / 1,800,380,572.11 = 55$
4. Хөрөнгийн өгөөж = борлуулалтын орлого / нийт хөрөнгө
 $XӨ = 8,812,255,031.28 / 9,535,128,524.67 = 0.92$
5. Өглөгийн эргэцийн тоо = Эргэлтийн хөрөнгө/богино хугацаат өр төлбөр
 $ӨЭТ = 6,576,884,334.37 / 5,591,931,384.04 = 1.18$
6. Өглөгийн эргэцийн өдөр = 365 / өглөгийн эргэцийн тоо
 $ӨЭӨ = 365 / 1.18 = 309$ өдөр

Мөнгөн хөрөнгийн шилжилтийн мөчлөг

ХАРЬЦАА	тооцох арга	2007 он	2008 он	2009 он
Бараа материалын шилжилтийн хугацаа	БМ/(жил бор /360)	82	63	75
Авлага цуглуулах хугацаа	Авлага/(жил бор/360)	322	164	187
Төлбөр хойшлуулах хугацаа	Авлага/(бор бүт өртөг/360)	339	173	197
Мөнгөн хөрөнгийн шилжилтийн мөч	БМШ + АЦ-ТХХ	64	53	65

1. Бараа материалын шилжилтийн хугацаа = БМ / (жил бор / 365)
 $БМШХ = 1,800,380,572.11 / (8,812,255,031.28 / 365) = 75$
2. Авлага цуглуулах хугацаа = Авлага / (жил бор / 365)
 $АЦХ = 4,304,257,616.26 / (8,812,255,031.28 / 365) = 178$
3. Төлбөр хойшлуулах хугацаа = авлага / (бор бүт өртөг / 365)
 $ТХХ = 4,304,257,616.26 / (8,302,128.480.0 / 365) = 189$ өдөр
4. Мөнгөн хөрөнгийн шилжилтийн мөчлөг = Бараа материалын шилжилтийн хугацаа +
авлага цуглуулах хугацаа – төлбөр хойшлуулах хугацаа
 $МХШМ = (75 + 178 - 189) = 64$ өдөр

өнөөдрийн байдлаар 61,9 мянган тн нүүрс олборлоод байна.2010 оноос эхлэн бүрэн хэмжээгээр ашиглалт явуулж эхлэхээр төлөвлөж байгаа юм.

- ТУЗ-ийн шийдвэрээр “ Шарын гол ” ХК ийн нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргах ажлын бэлтгэл ханган зохион байгуулах комиссийг томилон ажиллуулж байна.

- Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр “ Пантер Мидланд Аудит ” ХХК-ийг “ Шарын гол ” ХК-ийн аудитын компаниар сонгосон юм.

“ Шарын гол ” ХК-ийн улирал , жилийн санхүүгийн тайланг олон улсын стандартын дагуу хийгдсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт гаргуулан баталгаажуулж байх чиглэлээр дээрхи аудитын компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.

“ Пантер Мидланд Аудит ” ХХК нь “ Шарын гол ” ХК-ийн 2009 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансад аудит хийгээд<< “ Шарын гол ” ХК-ийн 2009 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангууд нь тайлбарын үндэслэлд дурьдсан зүйлсийг эс тооцвол бүх материаллаг зүйлсийн хувьд балансын өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон МУ-ийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль түүнд нийцүүлэн мөрдөж байгаа холбогдох заавар журмын дагуу зөв зүйтэй илэрхийлсэн байна>> гэж дүгнэжээ.

Цаашид жилийн эцсийн аудитыг хийж гүйцэтгэх явцад ажиглагдсан алдаа зөрчлүүдийг засаж залруулах , дотоод хяналтыг сайжруулах анхаарвал зохих зөвлөмж өгсөн байна.

- “ Шарын гол ” ХК нь нийт 7231389 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд 2010 оны 3 сарын 20-ны байдлаар 627 хувьцаа эзэмшигч манай хувьцааг эзэмшиж байна. Тус компанийн хувьцаа “ үнэт цаасны төлбөр тооцоо , төвлөрсөн хадгаламжийн төв ” ХХК-д хадгалагдаж байдаг бөгөөд үнэт цаас хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээг 2 тал жил бүр батлуулан ажиллаж ирлээ.

“ Шарын гол ” ХК-ийн хувьцаа нь “Би Ди Сек” , “Ники” , “Булган брокер” , “Дэлгэр хангай секюритиз” зэрэг брокер диллерийн компаниудад төвлөрсөн байна. Компанийн ТУЗ нь Монгол улсын компанийн тухай хууль , компанийн дүрмийг үндэс болгон цаашдын үйл ажиллагааны мөрдлөг болгон ажиллах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Pantheje Midland Audit LLC

Authorized Experts in Accounting, Audit, Consultation, and Assessment

Address: Room 404, Gurvangal Center, Sukhbaatar District
Ulaanbaatar, Mongolia

Tel: 319836
Fax: 976-11-319836

Date: 2010.02.24

№ Т-10/10
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

Бид “ШАРЫН ГОЛ” ХК-ийн (цаашид “Компани” гэх) 3-7 дугаар хуудсанд тусгагдсан 2009 оны 12 дугаар сарын 31-нээрх баланс, энэ өдрөөр дуусвар болсон жилийн орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж үнэн зөв танилцуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогоо сонгож, түүнийгээ тайлант жилийн туршид тогтвортой мөрдөх, бүртгэлээ Монгол улсын хуулийн дагуу зохион байгуулах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага болно. Мөн түүнчлэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөрөнгийг янз бүрийн зальт ажиллагаанд өртүүлэхгүй байхаар дотоод хяналтын системийг бий болгох, хэрэгжүүлэх нь удирдлагын хариуцлага юм.

Аудиторын хүлээх хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооноос гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр Стандарт нь санхүүгийн тайлангуудад материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажил нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодрууллагын үндэслэлийг тестийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналттай байж болох эрсдлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш бөгөөд тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцоолол, хэрэглэсэн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг. Бидний хийсэн аудитын ажил нь эдгээр санхүүгийн тайланд дүгнэлт гаргах хангалттай үндэслэл болж чадна гэж үзлээ.

“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ХЯНАН ШАЛГАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН - 2009 ОН

2010 оны 3-р сарын 15-ны өдөр

Дархан-Уул аймаг

Нэг. Танилцуулга

“Шарын гол” ХК-ийн Хянан Шалгах Зөвлөл нь 2009 онд Д.Нэргүй, Ө.Энхжаргал, Б.Эрдэнэтуяа нарын 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

Тайлант хугацаанд компанийн өмч, эд хөрөнгийг захиран зарцуулах санхүүгийн баримт бичигт 1-р гарын үсгийг гүйцэтгэх захирал С.Насанбат, 2-р гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Л.Даваасүрэн нар тус тус зурж захиран зарцуулжээ.

“Шарын гол” ХК нь санхүүгийн бүртгэлээ НББОУС-ын дагуу хөтөлж, тайлан тэнцлээ Дархан-Уул аймгийн татварын хэлтэст тушаадаг. “Шарын гол” ХК-ийн аудитын ажлыг “Пантер Мидланд аудит” компани хийдэг ба тус компанийн улирал, жилийн санхүүгийн тайланг олон улсын стандартын дагуу хийгдсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт гаргадаг.

Хоёр. Компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа

2.1. Хөрс хуулалт, олборлолт

“Шарын гол” ХК нь 2009 онд ТУЗ-өөс баталсан төлөвлөгөөний дагуу 2000.0 мян.м³ хөрс хуулж, 450.0 мян.тн нүүрс олборлож борлуулах төлөвлөгөөтэй ажилласнаас 1534.1 мян.м³ хөрс хуулан, 420.6 мян.тн нүүрс олборлон, 425.8 тн нүүрс борлуулжээ. Тайлант хугацаанд хөрс хуулалт 23.3%, нүүрс олборлолт 6.5%-иар дутуу биелсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хөрс хуулалт 35.7%-иар, нүүрс олборлолт 23.3%-иар тус тус буурсан үзүүлэлттэй харагдаж байна. Энэхүү бууралт нь машин техникийн цаг ашиглалт муу (38.2%), сул зогсолт их байсантай холбоотой юм.

2.2. Борлуулалтын орлого

“Шарын гол” ХК 2009 онд нүүрсний борлуулалтаас 10092.0 сая төг, бусад үйлчилгээнээс 145.8 сая төг буюу нийт 10237.8 сая төгрөгний орлого олохоор төлөвлөж байснаас 9126.9 сая төгрөгийн орлого олж, борлуулалтын орлого 89.1%-иар биелэгдэв. Энэ нь өмнөх оныхоос 17.1%-иар буурсан үзүүлэлт юм.

Борлуулалтын орлогын бүрэлдэхүүнд нүүрсний борлуулалт 94.5%-ийг эзэлж, үлдсэн 5.5%-ийг цайны газар, туслах аж ахуй, спортын ордон, амралт болон сэлбэгийн борлуулалт бүрдүүлж байна.

2009 онд ийнхүү компанийн орлого тодорхой хэмжээгээр буурсан нь нүүрсний чанар муу байсантай холбоотой. Илчлэгийн зөрүү, жингийн зөрүүнээс нийт 755.4 сая төгрөг олох боломжоо алдсан байна.

Дөрөв. Санхүүгийн байдалд хийсэн шинжилгээ

Компанийн санхүүгийн баримт, материалд тулгуурлан санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- *Төлбөрийн чадварын шинжилгээ:* Эргэлтийн харьцаа – 2009 онд 1.03-1.18 болж өссөн нь харьцангуй муу үзүүлэлт бөгөөд эргэлтийн өр төлбөрөө төлөхийн тулд эргэлтийн хөрөнгийг 18%-иас ихгүйгээр бууруулах боломжтой гэсэн үг. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа - 0.77-0.85 болж өссөн ба уг харьцаа 1-с их байх нь зохистой гэж үздэг тул компанийн хувьд хангалтгүй үзүүлэлт болж байна. Энэ нь хөрвөх чадвар хамгийн багатай бараа материалыг хассанаар төлбөрийг 85% гүйцэтгэх чадвартайг харуулж байна.
- *Үндсэн хөрөнгийн шинжилгээ:* Үндсэн хөрөнгийн эргэц - 0.95-0.76 болсон нь суурилуулсан машин, тоног төхөөрөмжийн ашиглалт 95%-иас 76% болж 19%-иар буурсныг харуулж байна. Нийт активын эргэц - 0.96 байгаа нь нийт активт оруулсан хөрөнгө оруулалтын ашиглалтын түвшин 96% болохыг илэрхийлж байгаа юм.
- *Ашигт ажиллагааны шинжилгээ:* Борлуулалтын ашигт ажиллагаа буюу цэвэр ашгийн түвшингийн хувьд борлуулсан бүтээгдэхүүний нэгж тутмаас 2008 онд 7 төгрөгийн, 2009 онд 27 төгрөгийн тус тус ашигтай ажилласан байна. Хөрөнгийн ашигт ажиллагаа – 2008 онд хөрөнгийн үлдэгдлийн нэгж тутмаас 6%, 2009 онд 23%-ийн ашигтай болсон байна.
- *Үр ашгийн харьцаа:* Авлагын эргэц - 2008 онд 2.2 буюу жилдээ 166 хоногт 1 удаа эргэж байсан бол 2009 онд 1.9 удаа буюу 190 хоногт эргэж байна. Энэ нь зээлээр борлуулсан бүтээгдэхүүнийхээ мөнгийг авахдаа 24 өдрөөр удааширсан таагүй үзүүлэлт гарчээ. Өглөгийн эргэц - 2008 онд 353 өдөр байсан бол 2009 онд 310 өдөр болж буурсан. Энэ нь эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрийг барагдуулах боломж багассаныг харуулж байгаа юм. Компанийн хувьд 2009 онд өр нийт дүнгээр буурсан нь өр төлбөрийг бууруулахад анхаарч ажилласан байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна. Хөрөнгийн өгөөж – Нийт хөрөнгийнхөө 96%-тай тэнцэх хэмжээний борлуулалт хийжээ. Бараа материалын эргэц – Бараа материалын үлдэгдэл жилд 55 удаа эргэж, дунджаар 6.6 хоногт 1 удаа борлогдож байна. 2008 онд 65 удаа буюу 5.6 хоног байсан нь 2009 онд муудсаныг илтгэнэ.
- *Мөнгөн хөрөнгийн шилжилтийн мөчлөг:* Авлага цуглуулах хугацаа – 2008 онд зээлээр борлуулсан бүтээгдэхүүнийхээ үнийг 164 хоногт авч байсан бол 2009 онд 187 өдөр болж 23 хоногоор хойшилсон нь тааруу үзүүлэлт юм. Төлбөр хойшлуулах хугацаа – 2008 онд 173 өдөр байсан бол 2009 онд 197 өдөр болж түүхий эд материал худалдан авах болон мөнгөөр хийх төлбөрүүдийн хугацаа 24 хоногоор хойшилсон байна. Мөнгөн хөрөнгийн шилжилтийн мөчлөг – 65 өдөр буюу 2.2 сарын үйлдвэрлэлийн зардлыг санхүүжүүлэхэд бэлэн эх үүсвэр хөрөнгө байх шаардлагатай гэсэн үг. Энэ мөчлөгийг бага байлгахын тулд борлуулалтыг түргэтгэж, авлага цуглуулах хугацааг богиносгох, төлбөр төлөх хугацааг уртасгах шаардлагатай.

2009 онд “Шарын гол” ХК-ийн үйл ажиллагаа болон компанийн удирдлага, албан тушаалтнуудын ажлын талаархи санал гомдол, шалгуулах тухай хүсэлт ТУЗ-ын Хянан Шалгах Зөвлөлд ирээгүй болно.

**Компанийн ТУЗ-ийн 2010 оны
зардлын төсөв**

Хавсралт №1

д/д	Зардлын төрөл	мян/төг
1	Гишүүдийн цалин	36360.0
2	Нарийн бичгийн даргын цалин	1920.0
3	Нийгмийн даатгалын шимтгэл	3828.0
4	Шуудан холбоо	5700.0
5	Бичиг хэргийн зардал	120.0
6	Хурлын зардал	1000.0
7	Томилолтын зардал	2400.0
8	Шатахуун	930.0
9	Гадаад томилолт	9750.0
10	Бусад	841.0
	Дүн	62849.0

ХШЗ-ийн 2010 оны зардлын төсөв

Хавсралт №2

д/д	Зардлын төрөл	мян/төг
1	Цалин	1980.0
2	Нийгмийн даатгалын шимтгэл	198.0
3	Бичиг хэргийн зардал	12.0
4	Томилолтын зардал	120.0
5	Байр	108.0
6	Бусад(унаа шатахуун)	279.7
	Дүн	2697.7

“Шарынгол” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд нэр
дэвшигчдийн товч танилцуулга.

1. Антони Милевский

- 1980 оны 6 сарын 27 нд төрсөн АНУ –ын иргэн
- АНУ-ын Бригхамийн их сургуулийн баклавар
- Вашингтоны их сургуулийн орос судлалын магистр
- Вашингтоны их сургуулийн хууль зүйн докторант
- ОХУ-ын хууль зүйн шинжлэх ухааны академи
- Хуульч мэргэжилтэй
- 2005-2006 Ринтейзэн Капитал
- 2007-2009 Тийгхер энд Флом компанид
- 2009 оноос Файр бёрд менежмент ХХК-д ажиллаж байгаа
- Ам бүл 2, эхнэрийн хамт амьдардаг.

2. Батхүүгийн Батмөнх.

- 1974 онд Улаанбаатар хотод төрсөн.
- 1992-1996 онд МУИС-ийн Эдийн засгийн сургууль
- 1998-2000 онд АНУ Калифорний их сургууль тус тус төгссөн.
- Санхүүч, корпорацийн санхүүч мэргэжилтэй.
- 1996 оноос Монгол банк Мөнгөний бодлогын газарт эдийн засагч
- 1996-1998 онд “Бодь лизинг санхүү” ХХК-д дэд захирал
- 2000-2001 онд “Орикс Консалтинг” ХХК-д захирал
- 2001-2008 онд “Би Энд Жи Эквиплинт” ХХК-д захирал
- 2008 оноос “Би Энд Жи” групп,уул уурхайн салбарын ерөнхийлөгч
- 2003 оноос одоо хүртэл “Шарынгол” ХК”ийн ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.
- Ам бүл 6. Эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг.

3. Жигжидсүрэнгийн Батболд

- 1964 онд Хөвсгөл аймгийн нутагт төрсөн.
- 1987 онд ОХУ /ЗХУ/ -ын Свердловскийн Уралын техникийн их сургууль
- 2000 онд Удирдлагын академи тус тус төгссөн.
- Уул уурхайн цахилгаан механик инженер, удирдлагын арга зүйч, бизнесийн ухааны магистр.
- 1987-1993 онд Дарханы техникийн коллежид багш
- 1993-1997 онд “Арвис” ХХК-д дэд захирал
- 1997-2000 онд Дархан-Уул аймаг дахь төрийн өмчийн хорооны төлөөлөгч
- 2001-2003 онд Дархан “Элексим” ХХК-д менежер
- 2003-2007 онд “Шарынгол” ХК-ийн ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал.
- 2007 оноос төслийн удирдагчаар ажиллаж байна.
- Ам бүл 5. Эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг.

4. Дамбачүлтэмийн Байлхүү

- 1947 онд Увс аймгийн нутагт төрсөн.
- 1978-1982 онд МУИС-ийн эдийн засгийн сургууль
- 1991, 1995 онуудад АНУ-ын Мерландын их сургуульд мэргэжил дээшлүүлсэн.
- 1993 онд МУИС-ийн ЭЗДС-д мастер
- Эдийн засагч мэргэжилтэй. Монгол улсын гавьяат эдийн засагч
- 1982-1991 онд Хөнгөн хүнсний үйлдвэрийн яаманд хэлтсийн дарга.
- 1991-1992 онд Засгийн газрын өмч хувьчлалын комиссын зөвлөх
- 1992-1996 онд Засгийн газрын өмч хувьчлалын комиссын нарийн бичгийн дарга.

- 1996 оноос Төрийн өмчийн хороонд зөвлөхөөр ажиллаж байна.
 - Ам бүл 2. Эхнэрийн хамт амьдардаг.
5. Цоодолын Ганбат
- 1975 онд Улаанбаатар хотод төрсөн.
 - 1999 онд ШУТИС-ийн ХМТИС төгссөн.
 - Холбооны инженер мэргэжилтэй.
 - 1993-1999 онд "Дөлгөөн Зааг" ХХК-д инженер.
 - 1999 оноос "Би Энд Жи" Интернэшнл" ХХК-ийн гүйцэтгэх захирал.
 - 2003 оноос "Шарынгол" ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.
 - 2008 оноос "Шарынгол Трейдинг ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.
 - Амбүл 5. Эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг.
6. Данзангийн Даянбилгүүн
- 1976 онд Улаанбаатар хотод төрсөн.
 - 1997 онд Европын хэлний дээд сургууль
 - 2006 онд Санхүү эдийн засгийн дээд сургууль төгссөн
 - Бизнесийн удирдлагын магистр
 - Одоо "Би Ди Сек" ХХК-ийн гүйцэтгэх захирал.
 - Ам бүл 2.
7. Жозеф Найэми.
- 1963 онд төрсөн. Австрали улсын иргэн.
 - Ираны Тегераны Маржааны сургууль
 - АНУ-ын Аризона мужийн Жадсоны сургууль
 - АНУ-ын Калифорни мужийн Чапманы их сургууль тус тус төгссөн.
 - Хувиараа бизнес эрхлэгч
 - Австралийн Чейз Петролиум ХХК-д
 - Голландын Чейз Энержи компанид
 - Канадын Куадра Рисурс корпорацид
 - Австралийн Фёст энержи ХХК-д
 - Австралийн Волант Петролиум зэрэг компаниудад ажиллаж байсан.
 - Одоо Австралийн Тритон Гидрокарбон компани, Сингапурын Тритон Коал компани, Австралийн Нинокс Петролиум комдани, Австралийн Нинокс Капитал зэрэг компаниудад ажиллаж байгаа.
 - Ам бүл 3. Эхнэр хүүхдийн хамт амьдардаг.
8. Шагдарсүрэнгийн Энхбаяр.
- 1975 онд Улаанбаатар хотод төрсөн.
 - 1992 онд 10 жилийн 11-р сургууль
 - 1996 онд МУИС-ийн ЭЗДС
 - 2005-2006 онд АНУ-ийн Калифорнийн их сургуульд тус тус суралцаж төгссөн.
 - Эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй.
 - 1996-1997 онд ТӨХ-д мэргэжилтэн
 - 1997-2002 онд "Номин Трейд" ХХК-д дэд захирал
 - 2002-2003 онд "Интер банк" –д дэд захирал
 - 2003 оноос "Номин Холдинг" ХХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.
 - Ам бүл 5. Эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг.
9. Жеймс Пассин
- АНУ-ын иргэн

SHARYN GOL JSC
APPLICATION FORM OF THE MEMBERS OF BOARD OF DIRECTORS

1. Surname: **Spence** Given name: **Ian Jason**
2. Birth of place: **Guisborough, England**
3. Date of birth: **1971 June 15th**
4. Nationality: **Australian**
5. Sex: **Male**
6. Origin of social ethnics: **English**
7. Where and when was educated from :

2001-2002	University of Western Australia (MBA)
1993-1994	University of Leicester, UK (MSc) Mineral Exploration & Mining Geology
1989-1993	University of Aberdeen, UK (BSc Hons) Geology & Petroleum Geology

8. Profession:
Geologist & Mining Company Director
9. The place and data of previous employment:

Mar 08-Feb 09 Resource Corporate Solutions Pty Ltd, West Perth, Western Australia, Associate Technical Director for a boutique venture capitalist and intermediary firm in the resources sector.

Mar 03-Mar 08 Montagu Corporate Pty Ltd (Montagu Stockbrokers), Perth Western Australia, Resources (Mining & Oil & Gas) Consultant to board of directors.

Jun 02-Mar 03 D.J. Carmichael Pty Ltd, Stockbrokers, Perth, Western Australia, Resources Analyst.

May 00-May 01 Plutonic Resources, West Australia, (Homestake Gold of Australia), Project Development Geologist.

Apr 97-May 00 Yilgarn Star Pty Ltd, Western Australia, Project Geologist for open cut and underground operations.

1996-97 British Steel Plc, Teesside Technology Centre, UK, Several roles on various Research & Development projects as a Geologist & Materials Scientist.

1995 Robe River Iron Associates (Rio Tinto), Western Australia, Exploration & Development Geologist.

1994-95 Hamersley Iron Pty (Rio Tinto), Western Australia, Exploration Geologist.

1994 Cementation Mining Ltd, UK, Engineering Geologist (Tunneling).

1990-93 British Steel Plc Teesside Technology Centre, UK, Various junior geological and technical roles.

10. Current employment:

Triton Coal Pte Ltd – Singapore

Ninox Petroleum Pty Ltd – Sydney, Australia

11. Family status / please indicate all members that you live with and their birth dates and occupations/ :

Spouse: Jenni-Lee Spence – Homemaker

Son: Bailey Martin Spence – infant

12. Working address: **Level 15, Country Centre, 74 Castlereagh Street, Sydney, NSW 2000, Australia**

13. Home address **5 Narelle Street, North Bondi, NSW 2026, Australia**

Signature:.....

A handwritten signature in black ink, appearing to read 'J. Spence', written over a dotted line. The signature is stylized and cursive.

“Шарынгол” ХК”ийн Хянан Шалгах Зөвлөлд
нэр дэвшигчдийн товч танилцуулга.

1. Өлзийбаярын Энхжаргал
 - 1979 онд Улаанбаатар хотод төрсөн
 - 2000 онд Монгол бизнес дээд сургууль
 - 2006 онд Сингапур улсад “Раффле” академи
 - 2008 онд СЭЗДЁ-д бизнесийн ухааны магистр
 - Санхүүч мэргэжилтэй
 - 2002 оноос “Би Энд Жи Эквипмент” ХХК-ийн тооцооны ня-бо, ерөнхий ня-бо, дэд захирал, санхүүгийн хэлтсийн даргаар ажиллаж байна.
 - 2008 оноос ШГХК-ийн ХШЗ-д сонгогдсон.
 - Ам бүл 2
2. Батхүүгийн Эрдэнэтуяа
 - 1976 онд Улаанбаатар хотод төрсөн.
 - Эдийн засагч мэргэжилтэй, мэргэжсэн нягтлан бодогч
 - 1998 онд НЭЗДС-ийг төгссөн,
 - 1998-2000 онд “Буян” ХХК-д нягтлан бодогч
 - 2000-2007 онд “Ган хийц” ХК-д ерөнхий нягтлан бодогч
 - 2007 онд “Эм Си Эс Электроникс” ХК-д нягтлан бодогч
 - 2007 оноос “Хар тэвш”-ийн уурхайн эдийн засагч, нягтлан бодогчоор ажиллаж байна.
 - 2008 оноос ШГХК-ийн ХШЗ-д сонгогдсон.
 - Ам бүл 4. Нөхөр хүүхдүүдийн хамт амьдардаг.
3. Өлзийдэлэгийн Эрдэмбилэг.
 - 1979 онд Улаанбаатар хотод төрсөн.
 - Бизнес судлаач, эдийн засагч мэргэжилтэй.
 - 2001 онд СЭЗДС төгссөн.
 - 2001-2003 онд “Монгол газар” ХХК-д эдийн засагч
 - 2003-2004 онд “ Би Энд Жи Эквипмент” ХХК-д төслийн дарга
 - 2004-2007 онд “Шарынгол Трейдинг” ХХК-д гүйцэтгэх захирал
 - Одоо “Эйч Ар” ХХК-ийн гүйцэтгэх захирал
 - Ам бүл 4. Аав, ээж, ах нарын хамт амьдардаг.